



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот

Суурь бүтцийн тарифт хөнгөлөлт тооцох тухай

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/154 тоот тушаалын 10 дугаар хавсралтаар баталсан “Суурь бүтэц ашиглалтын тариф тогтоох аргачлал” -ын 1.6 дахь заалт, мөн сайдын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/333 тоот тушаал, Зам, тээврийн хөгжлийн яамны 2024 оны 01 дүгээр 31-ний өдрийн 08/459 дугаартай албан бичиг, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.11, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын тээврийн суурь бүтцийн тарифт хөнгөлөлт үзүүлэх хувь хэмжээг нэгдүгээр хавсралтаар, хөнгөлөлт тооцох аргачлалыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалыг олон нийт, хамтран ажиллагч байгууллагуудад сурталчлан таниулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Тээвэр, ложистикийн төлөвлөлтийн газар /Г.Цолмонбаяр/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналтын алба /М.Эрдэнэсайхан/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ОТГОНСҮХ

2024090300

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын  
2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн  
1/37 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралт



**СУУРЬ БҮТЭЦ АШИГЛАЛТЫН ТАРИФТ ҮЗҮҮЛЭХ  
ХӨНГӨЛӨЛТИЙН ХЭМЖЭЭ**

Хүснэгт №1 Суурь бүтэц ашиглалтын ачаатай тээврийн тарифт үзүүлэх хөнгөлөлтийн хэмжээ

Ачаатай тээврийн хөлснөөс байршуулах урьдчилгаа төлбөр	Ачааны хэмжээ (Q), сая тонн									
	0.5≤Q≤0.7	0.7<Q≤0.8	0.8<Q≤0.9	0.9<Q≤1.0	1.0<Q≤1.1	1.1<Q≤1.2	1.2<Q≤1.3	1.3<Q≤1.4	1.4<Q≤1.5	1.5<Q
5%	0.1%	2.0%	4.5%	7.0%	9.5%	17.0%	20.0%	23.0%	27.5%	30.0%
6%	0.2%	2.5%	5.0%	7.5%	10.0%	17.5%	20.5%	23.5%	28.0%	30.5%
7%	0.5%	3.0%	5.5%	8.0%	10.5%	18.0%	21.0%	24.0%	28.5%	31.0%
8%	1.0%	3.5%	6.0%	8.5%	11.0%	18.5%	21.5%	24.5%	29.0%	31.5%
10%	1.5%	4.0%	6.5%	9.0%	11.5%	19.5%	22.5%	25.0%	29.5%	32.0%

Хүснэгт №2 Зүүнбаян-Цогтцэций (тэгш) чиглэлд тээврийн тарифын суурь бүтцэд ногдох тарифт үзүүлэх хөнгөлөлтийн хэмжээ

Ачаатай тээврийн хөлснөөс байршуулах урьдчилгаа төлбөр	Ачааны хэмжээ (Q), мян.тонн						
	100≤Q≤130	130<Q≤150	150<Q≤180	180<Q≤200	200<Q≤230	230<Q≤250	250<Q≤300
5%	0.5%	10.0%	15.0%	20.0%	24.5%	27.5%	30.0%
6%	1.0%	11.0%	16.0%	21.0%	25.0%	28.0%	30.5%
7%	1.5%	12.0%	17.0%	22.0%	25.5%	28.5%	31.0%
8%	2.0%	13.0%	18.0%	23.0%	26.0%	29.0%	31.5%
10%	3.0%	14.0%	19.0%	24.0%	27.0%	29.5%	32.0%

Тайлбар. Тээврийн тариф= Суурь бүтцийн тариф+зүтгүүр+вагон

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын  
2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн  
... дугаар тушаалын Хоёрдугаар хавсралт



## ХӨНГӨЛӨЛТ ТООЦОХ АРГАЧЛАЛ НЭГ. ЗОРИЛГО

Энэхүү аргачлалын зорилго нь суурь бүтцээр ачаа тээвэрлэгч байгууллагууд болон үйлчлүүлэгч байгууллагуудын ачааны хэмжээнээс хамаарсан хөнгөлөлтийг тооцож тээврийн хөлсний тооцоонд ашиглахад оршино.

### ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Хөнгөлөлт тооцох аргачлалыг зөвхөн энэ тушаалын нэгдүгээр хавсралтад заасан хөнгөлөлтийг тооцоход дагаж мөрдөнө.

2.2 Хөнгөлөлтийг тооцохдоо тухай бүр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тарифаас тооцно.

### ГУРАВ. СУУРЬ БҮТЭЦ АШИГЛАЛТЫН АЧААТАЙ ТЭЭВРИЙН ТАРИФТ ҮЗҮҮЛЭХ ХӨНГӨЛӨЛТИЙГ ТООЦОХ

3.1 Суурь бүтэц ашиглалтын ачаатай тээврийн тарифт үзүүлэх хөнгөлөлтийг зөвхөн ачаатай тээвэрт тооцох бөгөөд хоосон вагон тээвэр мөн сэлгээ, зам талбай ашиглалт гэх мэт бусад тарифт хамааруулан тооцохгүй болно.

3.2 Суурь бүтэц ашиглан тээвэр хийхээр гэрээ байгуулсан тээвэрлэгч байгууллагын ачаатай тээврийн хөлсний нийт үнийн дүнгээс урьдчилгаа байршуулах хувь болон гэрээнд заасан жилийн нийт ачааны хэмжээнээс хамааруулж нэгдүгээр хавсралтын хүснэгт 1-д заасны дагуу хөнгөлөлтийг суурь бүтцийн ачаатай тээврийн хөлсөнд тооцно.

*Жишээ-1: Жилд 1.5 сая тонн ачаа тээвэрлэхээр гэрээ байгуулж 10 хувийн урьдчилгаа төлбөр байршуулахаар тохиров. Энэ тохиолдолд нэгдүгээр хавсралтын хүснэгт 1-д заасны дагуу суурь бүтцийн ачаатай тээврийн хөлсөнд 29.5 хувийн хөнгөлөлт тооцно.*

3.3 Урьдчилгаа төлбөрийн дүнг тооцохдоо суурь бүтцийн ачаатай тээврийн хөлсний нийт үнийн дүнгээс урьдчилгаа байршуулах хувь, хөнгөлөлтийн хэмжээг тооцож бодно. Суурь бүтцийн ачаатай тээврийн тарифыг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тарифаар тооцно.

Суурь бүтцийн ачаатай тээврийн тариф 1 тонн.км-т ам.доллараар байх үед:

$$Атх=Вх*Т(\$)*Q*S$$

Тайлбар:

Ачаатай тээврийн хөлс- Атх, төгрөг

Гэрээ байгуулсан сарын эхний өдрийн валютын ханш- Вх, төгрөг

1 тонн.км-н тариф-Т(\$), ам.доллар

Гэрээнд заасан ачааны хэмжээ- Q, тонн

Ачаа тээвэрлэх зай- S, км

Суурь бүтцийн ачаатай тээврийн тариф 1 тонн.км-т төгрөгөөр байх үед:

$$Атх=Т(₮)*Q*S$$

Тайлбар:

Ачаатай тээврийн хөлс- А<sub>тх</sub>, төгрөг

1 тонн.км-н тариф-Т(₯), төгрөг

Гэрээнд заасан ачааны хэмжээ- Q, тонн

Ачаа тээвэрлэх зай- S, км

Дээрх томъёогоор ачаатай тээврийн хөлсийг бодож, уг дүнгээс урьдчилгаа төлбөрийн хувь хэмжээ, түүнд ногдох хөнгөлөлтийн хувиар тооцож “МТЗ” ТӨХК-ийн дансанд байршуулна.

3.4 Хөнгөлөлт тооцох ачааны хэмжээ нь нэгдүгээр хавсралтын Хүснэгт 1-д заасны дагуу 500 мянган тонн буюу түүнээс дээш хэмжээний ачаанд хамаарах бөгөөд гэрээнд заасан хугацаа хамгийн ихдээ 1 жил тээвэрлэхээр тооцно.

3.5 Гэрээнд заасан хугацаанаас өмнө захиалсан ачааны хэмжээг тээвэрлэсэн тохиолдолд гэрээг дүгнэж хаах учир нэмэлтээр тээвэрлэх ачаанд шинээр гэрээ байгуулж тус гэрээнд заагдсан ачааны хэмжээ, урьдчилгаа төлбөрт ногдох хөнгөлөлтийг олгоно.

3.6 Гэрээний хугацаа дуусах үед гэрээнд заасан ачааны хэмжээ биелээгүй тохиолдолд гэрээнд заасны дагуу тээвэрлэсэн ачааны хэмжээнд ногдох олговол зохих хөнгөлөлтийн хэмжээг бодож илүү олгосон хөнгөлөлтийн зөрүүнд ногдох дүнг “МТЗ” ТӨХК-д төлнө.

#### **ДӨРӨВ. ЗҮҮНБАЯН-ЦОГТЦЭЦИЙ (ТЭГШ) ЧИГЛЭЛД ТЭЭВРИЙН ТАРИФЫН СУУРЬ БҮТЦЭД НОГДОХ ТАРИФТ ҮЗҮҮЛЭХ ХӨНГӨЛӨЛТ ТООЦОХ**

4.1. Тээврийн тариф нь Суурь бүтцийн тариф+вагон ашиглалтын тариф+зүтгүүр ашиглалтын тариф гэсэн нийлбэртэй тэнцүү байна.

4.2. Тээврийн тарифын суурь бүтцэд ногдох тарифт үзүүлэх хөнгөлөлтийг зөвхөн Зүүнбаян-Цогтцэций тэгш чиглэлийн ачаатай тээврийн тарифын суурь бүтцэд ногдох тарифт тооцох бөгөөд хоосон вагон тээвэр мөн сэлгээ, зам талбай ашиглалт гэх мэт бусад тарифт хамааруулан тооцохгүй болно. Мөн суурь бүтэц ашиглалтад хамаарахгүй болно.

4.3. Зүүнбаян-Цогтцэций (тэгш) чиглэлд ачаа тээвэрлүүлэхээр гэрээ байгуулсан байгууллагын суурь бүтцийн ачаатай тээврийн хөлсний нийт үнийн дүнгээс урьдчилгаа байршуулах хувь болон гэрээнд заасан жилийн нийт ачааны хэмжээнээс хамааруулж нэгдүгээр хавсралтын хүснэгт 2-д заасны дагуу хөнгөлөлтийг зөвхөн ачаатай тээврийн суурь бүтцэд ногдох тарифт тооцно.

*Жишээ-2: Жилд 190,000 тонн ачаа тээвэрлэхээр гэрээ байгуулж 10 хувийн урьдчилгаа төлбөр байршуулахаар тохиров. Энэ тохиолдолд суурь бүтцийн ачаатай тээврийн хөлсөнд 24 хувийн хөнгөлөлтийг тооцно.*

4.4. Урьдчилгаа төлбөрийн дүнг тооцохдоо суурь бүтцийн ачаатай тээврийн хөлсний нийт үнийн дүнгээс урьдчилгаа байршуулах хувь, хөнгөлөлтийн хэмжээг тооцож бодно. Суурь бүтцийн ачаатай тээврийн тарифыг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тарифаар тооцно.

Суурь бүтцийн ачаатай тээврийн тариф 1 тонн.км-т ам.доллараар байх үед:

$$A_{тх} = B_x * T(\$) * Q * S$$

Тайлбар:

Ачаатай тээврийн хөлс- А<sub>тх</sub>, төгрөг

Гэрээ байгуулсан сарын эхний өдрийн валютын ханш- B<sub>x</sub>, төгрөг

1 тонн.км-н тариф-Т(\$), ам.доллар

Гэрээнд заасан ачааны хэмжээ- Q, тонн

Ачаа тээвэрлэх зай- S, км

Суурь бүтцийн ачаатай тээврийн тариф 1 тонн.км-т төгрөгөөр байх үед:

$$Атх=T(₮)*Q*S$$

Тайлбар:

Ачаатай тээврийн хөлс- Атх, төгрөг

1 тонн.км-н тариф-T(₮), төгрөг

Гэрээнд заасан ачааны хэмжээ- Q, тонн

Ачаа тээвэрлэх зай- S, км

Дээрх томъёогоор ачаатай тээврийн хөлсийг бодож уг дүнгээс урьдчилгаа төлбөрийн хувь хэмжээ, түүнд ногдох хөнгөлөлтийн хувиар тооцож “МТЗ” ТӨХК-ийн дансанд байршуулна.

4.5. Хөнгөлөлт тооцох ачааны хэмжээ нь нэгдүгээр хавсралтын Хүснэгт 2-д заасны дагуу 100 мянган тонноос 300 мянган тонн хүртэлх ачаанд хамаарах бөгөөд гэрээнд заасан хугацаа хамгийн ихдээ 1 жил тээвэрлэхээр тооцно.

4.6. Гэрээнд заасан хугацаанаас өмнө захиалсан ачааны хэмжээг тээвэрлэсэн тохиолдолд гэрээг дүгнэж хаах учир нэмэлтээр тээвэрлэх ачаанд шинээр гэрээ байгуулж тус гэрээнд заагдсан ачааны хэмжээ, урьдчилгаа төлбөрт ногдох хөнгөлөлтийг олгоно.

4.7. Гэрээний хугацаа дуусах үед гэрээнд заасан ачааны хэмжээ биелээгүй тохиолдолд гэрээнд заасны дагуу тээвэрлэсэн ачааны хэмжээнд ногдох олговол зохих хөнгөлөлтийн хэмжээг бодож илүү олгосон хөнгөлөлтийн зөрүүнд ногдох дүнг “МТЗ” ТӨХК-д төлнө.

#### ТАВ. БУСАД

5.1. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд Хүснэгт 1, 2-д заасан урьдчилгаа төлбөрийн хувь хэмжээнд Гүйцэтгэх захирлын шийдвэрээр өөрчлөлт оруулж болно.

5.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл болон захиалагчийн үйл ажиллагаанаас үл хамаарсан шалтгаанаар тээврийн хэмжээ биелээгүй тохиолдолд гэрээнд заасан ачааны хэмжээ, урьдчилгаа төлбөрт хамаарах хөнгөлөлтийг тооцно.

-оОо-